

“МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-Д НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЧИГЛЭЛЭЭР ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Нийгмийн даатгалын ерөнхий газар (2025 оны жилийн эцсийн байдлаар)

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин (Хувь)	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар)	Гүйцэтгэлийн хувь
				Он	Түвшин (Хувь)			
НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО								
Зорилго 3.4.1. Тэтгэврийн насны хүн амын нийгмийн баталгааг дээшлүүлнэ.								
3.4.1.1	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлэх	Улсын төсөв (304,726.7)	Тэтгэврийн нэмэгдлийн хувь	2024	22.7	6	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт “Тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинтэй уялдуулж жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлнэ” гэж заасны дагуу Засгийн газрын 2024 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 221 дүгээр тогтоолоор нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 хувиар нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 689.0 мянган төгрөгөөр, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 572.4 мянган төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоов. Уг тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхэд шаардагдах 300.1 тэрбум төгрөгийн төсвийг Нийгмийн даатгалын сангийн 2025 оны Төсвийн тухай хуулиар батлуулж 505.6 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулсны дүнд дундаж тэтгэвэр 832.7 мянган төгрөгт хүрч 6 хувиар өссөн болно.	100
ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ								100